

**МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН САЙДЫН  
ТУШААЛ**

2013 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.6 дугаар заалт, Төсвийн тухай хуулийн 15.4, 38, 41 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмыг 1 дүгээр хавсралтаар баталсугай

Хоёр. Энэхүү батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Жигжидэд даалгасугай.

Гурав. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх үр дүнг тооцох журмыг баталсантай холбогдуулан Үйлдвэр, худалдааны сайдын 2006 оны 11 сарын 24-ний өдрийн “Журмууд батлах тухай” 214 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Д.ГАНХУЯГ

## **Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөний төсөл зохиох, хянах, батлах, түүнд зориулан улсын төсвөөс олгох хөрөнгийг хуваарилах, санхүүжүүлэх, гүйцэтгэлийн хяналт тавих, тайлан мэдээ гаргах, үр дүнг хүлээн авах харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Геологийн судалгааны ажил гэдэгт Монгол Улсын "Ашигт малтмалын тухай" хуулийн 11.1.1-3, 11.1.5 дүгээр зүйлд заасан региональ геологи, геохими, гидрогеологийн зураглал, геоэкологи, геофизикийн болон ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэлбэршилтийн судалгаа, сэдэвчилсэн судалгаа, үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлж, баяжуулах, эрдэс баялгийн үнэлгээ хийх зэргийг хамруулж ойлгоно.

1.3 Геологийн судалгааны ажилд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн ерөнхийлөн захирагч нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд байна.

### **Хоёр. Геологийн судалгааны ажлыг төлөвлөх**

2.1 Ашигт малтмалын газар нь дараа жилд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа бусад яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газраас жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор холбогдох саналыг авна. Ирүүлсэн саналуудыг судлан үзэж төр, засгийн бодлогод нийцсэн, нэн шаардлагатай төслүүдийг энэхүү журмын 2.3-д заасан төлөвлөгөөний төсөлд тусгана.

2.2 Судалгааны талбайг сонгохдоо бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүс нутгийн хөгжлийг жигд хангах, геологийн тогтоцыг нарийвчлан судлан тогтоох, давхраажсан хурдас болон гүний чулуулгийг нарийвчлан ангилах, металлогенийн муж, бүс, голлох хүдрийн дүүрэг, зангилаануудыг бүрхэх, дэлхийн болон бүс нутаг, улс орны зах зээл дээр стратегийн ач холбогдолтой эрдэс түүхий эдийг богино хугацаанд, бага зардлаар судлан үр дүнд хүрэх зарчмыг баримтална.

2.3 Ашигт малтмалын газар/АМГ/ нь дараа жилд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөний төслийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын бодлогын баримт бичиг, дараа онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн саналын хүрээнд судалгааны объект бүрээр зохиож, энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу нэгтгэн боловсруулж, түүнийг хэлэлцэж гаргасан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ)-ийн дүгнэлтийн хамт жил бүрийн 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллагад хүргүүлнэ.

2.4 Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Ашигт малтмалын газрын боловсруулсан геологийн судалгааны ажлын төлөвлөгөөний төслийг хянаж 4 дүгээр сарын 1-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусгуулна.

2.5 Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл Монгол Улсын Их Хурлаар батлагдаж, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд-Төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн санхүүгийн жилийн төсвийн багц батлагдсаны дараа төлөвлөгөөт онд Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөө, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны дотор баталж, Ашигт малтмалын газарт мэдэгдэнэ. Шинэ төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, үргэлжлэх төслүүдийн тодотгол хийгдэж дууссаны дараа Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын тодотгосон төлөвлөгөөг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батална.

2.6 Ашигт малтмалын газар нь тухайн жилийн төлөвлөгөө батлагдсаны дараа шинээр хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын геологийн даалгаврын төслийг 11 дүгээр сарын 15-ны дотор боловсруулан геологи, эрдэс баялгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, геологийн төлөвлөлт хариуцсан нэгж нь хянаж, холбогдох нэгжүүдээс санал авч геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн дэд сайдаар батлуулна.

2.7 Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологийн судалгааны ажлын аргачлал, ажлын хэмжээ, төсөвт өөрчлөлт орсон тохиолдолд АМГ-ын Геологийн алба тухайн жилийн 12 дугаар сарын 20-ний дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, төслүүдийн төсвийн тодотголыг дараа жилийн 4 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлнэ. ЭБМЗ-өөс гаргасан зөвлөмжийг үндэслэн төсвийн тодотголыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайдаар батлуулж санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.8 Үргэлжлэн хэрэгжиж байгаа геологийн судалгааны ажлын тухайн жилийн төсвийн тодотголд тусгах үнийн тохируулгын саналыг АМГ-ын Геологийн алба боловсруулан тухайн жилийн 3 дугаар сарын 01-ны дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Тухайн төслийн төсөвт үнийн тохируулга хийх АМГ-ын Геологийн албаны саналыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжилан шийдвэрлүүлнэ.

2.9 Магадлашгүй ажлын зардлыг тухайн төслийг гүйцэтгэх явцад гарсан урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд хээрийн шуурхай хяналт ба ЭБМЗ-ийн дүгнэлтийг тус тус үндэслэн зарцуулна.

2.10 Тухайн жилд хэрэгжих төсөл бүрийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Ашигт малтмалын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусган геологийн даалгаврын биелэлт, ажлын явц, үр дүнд хяналт тавьж,

мэргэжлийн зөвлөгөө өгч, байгууллагын зүгээс гэрээний биелэлтийг хянах, дүгнэх ажлыг зохион байгуулна.

### **Гурав. Геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх**

3.1 Ашигт малтмалын газар нь тухайн жилийн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөө батлагдсаны дараа төслүүдийн санхүүжилтийн хуваарийг 2 дугаар хавсралтын дагуу хийж, 12 дугаар сарын 20-ны дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.2 Геологийн судалгааны ажлыг эхлэх бэлтгэлийг хангах зорилгоор төслийн урьдчилгаа санхүүжилтийг төслийн тухайн жилийн төсөвт өртөгийн 20 хувь хүртэл хэмжээгээр олгож болно. Энэхүү урьдчилгаа санхүүжилтийг шинэ төслийн хувьд судалгааны ажил хэрэгжүүлэх гэрээ байгуулсны дараа, үргэлжлэх төсөлд оны эхнээс олгоно.

3.3 Төсөл хэрэгжүүлэгчид тухайн жилийн төсөв батлагдсаны дараа төсөл тус бүрийн ажлын гүйцэтгэлийн актыг энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу үнэн зөв, алдаа, засваргүй 3 хувь үйлдэж, холбогдох баримтын хамт дараа сарын 1-ний өдрийн дотор Ашигт малтмалын газарт сар бүр хүргүүлнэ.

3.4 АМГ-ын Геологийн алба төсөл хэрэгжүүлэгчдээс ирүүлсэн ажлын гүйцэтгэлийн актыг ажлын төрөл бүрээр зардлын задаргааны хамт гаргуулан хүлээн авч, хянан баталгаажуулж, энэхүү журмын 4 дүгээр хавсралтын дагуу нэгтгэнэ. Ажлын гүйцэтгэлийн нэгтгэлийг АМГ-ын дарга зөвшөөрсний дараа 3 хувь үйлдэн дараа сарын 5-ны өдрийн дотор 5 дугаар хавсралтын хамт геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ. Тус нэгж гүйцэтгэлийг хянан төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бөгөөд геологийн судалгааны ажлын санхүүжилтийг шуурхай хийнэ.

3.5 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын 3 хоногт багтаан батлагдсан төсвийн хуваарьтай уялдуулан хянаж, геологийн судалгааны ажлын санхүүжилтийн эрхийг нээх бөгөөд геологийн судалгааны санхүүжилтийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын геологийн судалгааны ажлын санхүүжилтийн 900018006 дансаар дамжуулан гэрээнд заасан гүйцэтгэгчдийн харилцах дансанд шилжүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч санхүүжилтийн дансаа сольсон тохиолдолд ажлын 3 өдрийн дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр мэдэгдэж байна.

3.6 Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсөл тус бүрээр шаардлагатай санхүүжилтийг тооцон тодорхойлж, мөнгө дансанд орж ирснээс хойш ажлын 3 хоногт багтаан энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу төсөл хэрэгжүүлэгчдэд хуваарилан санхүүжүүлнэ.

3.7 Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон шуурхай хяналтын комисс нь төслийн ажлын явцтай газар дээр нь танилцан, төсөл хэрэгжүүлэгчдээс гаргасан ажлын аргачлал, биет хэмжээнд өөрчлөлт оруулах саналыг шийдвэрлэж, энэ тухай тэмдэглэлийг Геологийн албанд хүргүүлнэ. Геологийн алба тухайн төслийн төсөвт тусгасан биет хэмжээнээс илүү, дутуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг

төсөл хэрэгжүүлэгчдээс ирүүлсэн албан ёсны хүсэлт, шуурхай хяналтын хурлын тэмдэглэл, хээрийн ажил хүлээн авсан актыг үндэслэн АМГ-ын даргын шийдвэрийг гаргуулж 12 дугаар сарын 10-ны дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3.8 Төслийн сүүлийн жилийн төсвийн өөрийн хүчээр гүйцэтгэсэн ажлын дүнгийн 20 хувийг барьцаанд байлгаж, төслийн үр дүнг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, Геологийн мэдээллийн төв архив" (ГМТА)-д хүлээлгэн өгсөний дараа буцаан олгоно.

3.9 Гүйцэтгэгч нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд бусдаар гүйцэтгүүлэх ажил (геофизикийн ажил, лабораторийн шинжилгээ, ажлын хэрэгцээний байр зүйн зураг, агаар болон сансрын зураг, түүний тоон мэдээлэл, тайлангийн зургуудыг захиалж хэвлүүлэх болон бусад шаардлагатай ажил, үйлчилгээ, бараа материал)-ыг заавал гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ. Төсөл дуусахад гэрээг дүгнэсэн байна.

3.10 Гүйцэтгэгч нь улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны бүх төрлийн дээж, сорьцын шинжилгээг Геологийн төв лаборатори /ГТЛ/ болон зөвхөн итгэмжлэгдсэн бусад лабораториор гэрээгээр гүйцэтгүүлнэ. Төсөл гүйцэтгэгчийн хийлгэсэн лабораторийн шинжилгээний ажлын гүйцэтгэлийг байгуулсан гэрээ болон итгэмжлэгдсэн лабораторийн нэхэмжлэхийг АМГ-ын Геологийн алба хянаж, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэгтгэсэн мэдээллийг хүргүүлнэ.

3.11 Геологийн судалгааны төслийн хэрэгжилтийн явцад геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дотоод аудитын асуудал хариуцсан нэгжийн хяналт, шалгалтын зардал, хяналт тавихад шаардагдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, ажлын гүйцэтгэлийг хэмжин шалгах, судалгааны явцад гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхээр дээж, сорьц авч, лабораторийн шинжилгээ хийлгэх, Монголын стратиграфийн комисс (МСК)-ын ажлын зардлыг санхүүжүүлэх, үр дүнгийн тайланд шүүмж бичүүлэх, тайланг ЭБМЗ-өөр хэлэлцэхтэй холбогдож гарах зардал, геологийн судалгааны ажлыг өндөр үр дүнтэй гүйцэтгэж, үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр амжилттай буюу онцсайн хамгаалсан гүйцэтгэгчдийг урамшуулан шагнах зэрэгт зориулан зарцуулах аргачлал, хяналтын зардлыг төсөл тус бүрийн өөрийн хүчээр гүйцэтгэх ажлын нийт дүнгийн 2.0 хувьтай тэнцэх хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгчдээс геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардлын 900018004 дансанд төвлөрүүлэн зарцуулна.

3.12 Геологийн судалгааны ажлын тухайн жилийн аргачлал хяналтын зардлын төсвийг Ашигт малтмалын газраас ирүүлсэн саналыг үндэслэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга батална.

3.13 Батлагдсан аргачлал хяналтын зардлын төсөв болон Ашигт малтмалын газраас ирүүлсэн холбогдох баримт, материалыг үндэслэн геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардлын санхүүжилтийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан олгоно.

3.14 Геологийн даалгавраар өгөгдсөн асуудлуудыг судалгааны оновчтой шинэлэг арга аргачлалаар гүйцэтгэж, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр онолын өндөр түвшинд геологийн асуудлуудыг шийдвэрлэсэн, онолын хувьд маргаантай байгаа асуудлыг

шийдвэрлэх ач холбогдол бүхий баримтыг олж тогтоосон болон ашигт малтмалын хувьд хэтийн төлөвтэй эсэхийг бүрэн эцэслэн шийдвэрлэж, тайланг хугацаанд нь амжилттай хамгаалсан гүйцэтгэгчдийг, төсөлд зарцуулсан нийт зардлын дүнгийн 0.5% хүртэл хэмжээгээр урамшуулан шагнаж болно. Шагналын хувь, хэмжээг ЭБМЗ-ийн дүгнэлтийг үндэслэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд шийдвэр гаргана.

3.15 Төслийн геологийн даалгаврын хугацааг хэтрүүлж хэрэгжүүлсэн тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төсөлд зарцуулсан нийт зардлын дүнгийн 0.03 хувьтай тэнцэх хэмжээний алданги төсөл хэрэгжүүлэгчид ногдуулах ба энэ тухай Ашигт малтмалын газар нь Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Улсын хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

3.16 Төсөл хэрэгжүүлэгч нь Ашигт малтмалын газрын даргын 1997 оны 53 дугаар тушаалд заасан бүтэц, агуулгатайгаар төсөл нэг бүрээр нь судалгааны ажлын үр дүнг дэлгэрэнгүй тусгасан улирлын тайланг тухайн улирлын сүүлийн сарын 25-ны дотор Ашигт малтмалын газрын Геологийн албанд ирүүлсэн байна.

3.17 Ашигт малтмалын газар геологийн судалгааны ажлын үр дүн, санхүүжилтийн тайланг улирал бүр нэгтгэн гаргаж, дараа сарын 5-ны дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.18 Төсөл хэрэгжүүлэгч геологийн судалгааны ажлын гүйцэтгэл, мэдээ, тайланг хугацаанд нь ирүүлээгүй, төслийн арга аргачлал зөрчсөн, Ашигт малтмалын газартай тохиролцолгүйгээр төсөлд заагаагүй ажил гүйцэтгэсэн, шуурхай хяналтын үед илэрсэн зөрчил дутагдлыг арилгаагүй, зөрчил гаргасны төлөө тавьсан актын дагуу төлбөр торгуулийг барагдуулаагүй, төсөл хэрэгжүүлэх явцад олж авсан геологи, эрдэс баялгийн холбогдолтой мэдээллийг нуун дарагдуулсан, төсөл дээр ажиллаж байгаа голлох мэргэжлийн хүмүүсийг олон удаа өөрчилсөн нь ажлын чанар, үр дүнд сөрөг нөлөө үзүүлсэн, геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн, геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хамгаалаагүй, Геологийн мэдээллийн төвд хүлээлгэн өгөөгүй тохиолдолд Ашигт малтмалын газраас ирүүлсэн тайланг үндэслэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүүжилтийг нь зогсоох, дээр дурьдсан төлбөр торгуулийг барьцаа хөрөнгөөс барагдуулах, дараагийн жилийн төслийн сонгон шалгаруулалтад оруулахгүй байх тухай тендерийн хороонд хандах хүртэл арга хэмжээ авна.

3.19 Төсөл хэрэгжүүлэгч геологийн судалгааны ажлыг өөрийн санаачлагаар дур мэдэн зогсоосон, олгосон хөрөнгийг зориулалт бусаар ашигласан, арга аргачлалын алдаа гаргасан, хангалтгүй гүйцэтгэсэн, ажлын үр дүнгийн тайланг зохиож ЭБМЗ-өөр хамгаалаагүй, тайланг үрэгдүүлсэн тохиолдолд уг төсөлд улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгчээр улсын төсөвт эргүүлэн төлүүлэх тухай Геологи уул уурхайн асуудал эрхэлсэн хяналтын байгууллагад хандана.

3.20 Геологийн судалгааны ажлын санхүүжилтийн дансны гүйлгээнд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайдын багцын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн гарын үсэг зурж, судалгааны санхүүжилтийн тайлан тэнцэл гарган бүртгэлийн хяналт

тавина.

3.21 Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн төсөв, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн худалдаанаар хэлэлцүүлэхдээ 7 дугаар хавсралтын дагуу төсөл гүйцэтгэх хугацаанд гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл, гүйцэтгээгүй ажлын дүн, илүү, дутуу гүйцэтгэсэн ажлын хэмжээг он бүрээр гаргаж, өөрийн хүчээр гүйцэтгэсэн ажлын санхүүжилт аваагүй гүйцэтгэлийг дараа жилийн геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд оруулах саналаа жил бүрийн 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор Ашигт малтмалын газарт ирүүлнэ.

3.22 Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн төсөв, төсвийн тодотголын төслийг 8 дугаар хавсралтад тусгагдсан хүснэгтийн дагуу хийж, геологийн судалгааны ажлын арга аргачлалын хамт жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор Ашигт малтмалын газарт ирүүлэх.

3.23 Улсын төсвийн хөрөнгөөр төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн геологийн судалгааны ажлын гүйцэтгэл, түүний зардлын задаргааг ажлын нэр төрөл бүрээр 9 дүгээр хавсралтийн дагуу гаргаж, жилийн эцсийн тайландаа хавсаргана.

### **Дөрөв. Геологийн судалгааны ажилд хяналт тавих**

4.1 Төсөл хэрэгжүүлэгчдийн ажлын үр дүн болон ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор хээрийн судалгааны болон суурин боловсруулалтын ажлын гүйцэтгэлд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Ашигт малтмалын газрын Геологийн албанаас шуурхай хяналтыг гүйцэтгэн төсөл зохих арга, аргачлалын дагуу хэрэгжиж байгаа эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг шалгаж, аргачлалын зөвлөгөө өгнө. Шуурхай хяналтад салбарын тэргүүлэх эрдэмтэд, мэргэжилтнүүдийг оролцуулж болно.

4.2 Шуурхай хяналтын үед ажлын гүйцэтгэлийг газар дээр нь холбогдох баримт материал, мэдээ, мэдээлэлтэй танилцах, хэмжин шалгалт хийх замаар баталгаажуулж, энэ тухай протокол, актыг үйлдэнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь төсөлтэй холбоотой бүх баримт материал, мэдээ, мэдээллийг саадгүй үзүүлж, танилцуулах, хүргүүлэх үүрэгтэй.

4.3 Хээрийн судалгааны үед геологийн даалгаварт тусгасан асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн үед шинэ гарсан үр дүн, баримтыг үндэслэн ажлын арга аргачлал, хэмжээнд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах зохицуулалтыг газар дээр нь авч хэрэгжүүлнэ. Шуурхай хяналтын илтгэх хуудсанд зохицуулалт хийх үндэслэл, хийх арга замыг тодорхой дурьдаж АМГ-ын Геологийн алба нь тодорхой шийдвэрийн төслийг бэлтгэн АМГ-ын удирдлагад танилцуулж, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн шийдвэр гаргуулна.

4.4 Шуурхай хяналтаар төсөл хэрэгжүүлэгчээс судалгааны ажлын аргачлалыг зөрчсөн, хийгээгүй ажлыг гүйцэтгэлд оруулж, илүү санхүүжилт авсан нь тогтоогдвол ажлын гүйцэтгэлээс хасах, уг ажлыг нөхөн хийлгэх арга хэмжээ авна.

4.5 Төслийг хэрэгжүүлэгчийн гаргасан зөрчил нь ноцтой, учруулсан болон учруулж

болзошгүй үр дагавар нь ач холбогдлоороо хортой үр дүнтэй тохиолдолд төслийн ажлыг зогсоох хүртэл арга хэмжээг шуурхай хяналтын хэсэг авч болно. Шуурхай хяналтын хэсэг нь авсан арга хэмжээний тухай Ашигт малтмалын газрын даргад танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулан баталгаажуулж геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.6 Хээрийн судалгааны ажил дууссаны дараа гүйцэтгэгчийн хээрийн судалгаагаар бүрдүүлсэн анхдагч баримт, материалыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон геологийн албаас томилогдсон комисс хүлээн авна. Заавар, шаардлагын хэмжээнд анхдагч баримтыг бүрдүүлээгүй, бүрдүүлсэн материал нь суурин боловсруулалтын явцад геологийн даалгавраар өгөгдсөн асуудлыг шийдвэрлэх боломжгүй болох нь хээрийн материалыг хүлээх авах явцад тогтоогдвол хугацаа заан үүрэг өгөх эрхийг комисс эдэлнэ. Заасан хугацаанд өгсөн үүргийг шаардсан хэмжээнд биелүүлээгүй тохиолдолд төслийг түр зогсоон гэрээний дагуу үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчийн асуудлыг Геологийн албаны даргад танилцуулж, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас холбогдох шийдвэрийг гаргуулна.

4.7 Хээрийн шуурхай хяналт хийх болон хээрийн материалыг хүлээн авах хяналтын хуудсыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлуулан, мөрдөн ажиллана.

### **Тав. Судалгааны ажлын үр дүнг хүлээн авах, мэдээлэх**

5.1 Төсөл хэрэгжүүлэгч геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг 2 хувь зохиож, Геологийн албанаас хүлээн зөвшөөрсөн мэргэжилтнүүдээр шүүмж хийлгэж, МСК-ийн дүгнэлт гаргуулсны дараа ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж хамгаална.

5.2 Төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, гаргасан тэмдэглэл, дүгнэлтэд тайланг хүлээн авах эсэх тухай зөвлөмжийг үндэслэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд шийдвэр гаргана. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайдын шийдвэрийг үндэслэн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, анхдагч материалыг Геологийн мэдээллийн төв архив /ГМТА/ хүлээн авна. Тайлан, анхдагч материалыг ГМТА-д хүлээн авна. Тайлан холбогдох материалыг ГМТА-д хүлээлгэн өгсний дараа Ашигт малтмалын газрын Геологийн алба нь “Геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээ”-г дүгнэсэн дүгнэлтийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж гэрээг дуусгавар болгоно.

5.3 Төсөл хэрэгжүүлэгч геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайлангийн хамт төсвийн хөрөнгөөр бэлтгэгдсэн хээрийн судалгааны анхдагч материал, агаар, сансрын зураг тэдгээрийн тоон мэдээлэл, тайланг электрон хэлбэрээр Геологийн мэдээллийн төв архивт хүлээлгэн өгнө.

5.4 Төсөл хэрэгжүүлэгчээс геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг хүлээлгэн өгсөн тухай мэдэгдлийг ГМТА нь Ашигт малтмалын газарт энэ журмын 6 дугаар хавсралтын дагуу ирүүлэх бөгөөд АМГ нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

5.5 ГМТА нь тайлан, анхдагч материалыг хүлээн авах тухай холбогдох эрх бүхий албан



тушаалтны шийдвэрийг хүлээн авч, түүний дагуу гүйцэтгэгчээс энэхүү журмын 5.3-д заасан зүйлсийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор багтаан өөрийн фондын үйлчилгээний мөрдөх журам, зааврын дагуу бүртгэлд тусган дугаарлан баримтжуулснаар нийтийн хэрэгцээнд батлагдсан тарифт үнэлгээгээр үйлчилнэ.

5.6 Төсөл хэрэгжүүлэгч геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг хүлээн авах талаар АМГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистик мэдээллийн нэгжээр төслийн гүйцэтгэлийн санхүүжилт болон геологийн даалгавар биелэгдсэн эсэхийг хянуулан дүгнэлт гаргуулж ЭБМЗ-өөр хэлэлцүүлнэ.

"Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 1 дүгээр хавсралт

20 ...оны ... дугаар сарын ...-ний өдөр

... төслийн талбайд 20 ... онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөө

өгрөг/

| 0 | Ажлын нэр төрөл | Өмнөх оны ажлын гүйцэтгэл/өссөн дүнгээр/ | Геологийн даалгавар, шийдвэрлэх асуудал, хугацаа | Тухайн онд гүйцэтгэх ажил | Тухайн оны санхүүжилтийн хэмжээ |
|---|-----------------|--|--|---------------------------|---------------------------------|
| 0 | 1               | 2  | 3  | 4                         | 5                               |
| 1 |                 |  |  |                           |                                 |
|   |                 |  |  |                           |                                 |
|   |                 |  |  |                           |                                 |

УУЯ-ны Геологийн бодлогын хэлтсийн дарга

УУЯ-ны ЭЗСХОХ-ийн дарга

АМГ-ын Геологийн албаны дарга

"Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 2 дугаар хавсралт

20 ...оны ... дугаар сарын ...-ний өдөр

**Геологийн судалгааны ажлын төсөл хэрэгжүүлэгчид олгох санхүүжилтийн хуваарь**

| /төгрөг/ |                    |               |              |
|----------|--------------------|---------------|--------------|
| Д/д      | Төсөл хэрэгжүүлэгч | Эрхийн дугаар | Олгох хэмжээ |
| 0        | 1                  | 2             | 3            |
|          |                    |               |              |
|          |                    |               |              |
|          |                    |               |              |

Зөвшөөрсөн:

УУЯ-ны ЭЗСХОХ-ийн дарга /...../

УУЯ-ны ЭЗСХОХ-ийн мэргэжилтэн /...../

Танилцсан:

АМГ-ын ГА-ны дарга /...../

Хянасан:

АМГ-ын ГА-ны РСТ-ийн дарга /...../

Нэгтгэн боловсруулсан:

АМГ-ын ГА-ны РСТ-ийн мэргэжилтэн /...../

"Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх  
геологийн судалгааны ажлыг  
санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох  
журам"-ын 3 дугаар хавсралт

**Ажлын гүйцэтгэлийн акт**

20.. оны ... дүгээр сарын 1-ээс ... дүгээр сарын 1-ний өдөр хүртэл

Төсвийн дүн: ..... /төгрөгөөр/  
₮рөг/

| Д/д | Ажлын төрөл | Хэмжих нэгж | Нэгжийн өртөг | Тайлант сарын<br>гүйцэтгэл |     | Оны эхнээс гарсан<br>гүйцэтгэл |     |
|-----|-------------|-------------|---------------|----------------------------|-----|--------------------------------|-----|
|     |             |             |               | Тоо                        | Дүн | Тоо                            | Дүн |
|     |             |             |               |                            |     |                                |     |
|     |             |             |               |                            |     |                                |     |

... компанийн захирал /...../  
Ахлах геологич /...../  
Эдийн засагч, ня-бо /...../

"Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 4 дүгээр хавсралт

20 ...оны ... дугаар сарын ...-нийөдөр

Геологийн зураглалын ажлын ... оны ... дугаар сарын гүйцэтгэлийн нэгтгэл /Зардал тус бүрээр/

| Д/д | Төсөл хэрэгжүүлэгчийн нэр | Төслийн нэр | 20 .. оны төсөв | Ажлын нэр | Ажлын гүйцэтгэл |            | Санхүүжилт   |            | Цалин хөлс | Материалын зардал | Хангамжийн зардал/хоол хүнс/ | Бичиг хэрэг | Томилолт | Хээрийн нэмэгдэл | Түлш, шатахуун, тос тосолгооны материал | Тээврийн зардал | Холбоо | ..... | Бусад зардал | Зардлын дүн |
|-----|---------------------------|-------------|-----------------|-----------|-----------------|------------|--------------|------------|------------|-------------------|------------------------------|-------------|----------|------------------|---|-----------------|--------|-------|--------------|-------------|
|     |                           |             |                 |           | Тайлант сард    | Оны эхнээс | Тайлант сард | Оны эхнээс |            |                   |                              |             |          |                  |   |                 |        |       |              |             |
| 0   | 1                         | 2           | 3               | 4         | 5               | 6          | 7            | 8          | 9          | 10                |                              | 11          | 12       | 13               | 14                                      | 15              | 16     |       |              |             |
|     |                           |             |                 |           |                 |            |              |            |            |                   |                              |             |          |                  |   |                 |        |       |              |             |
|     |                           |             |                 |           |                 |            |              |            |            |                   |                              |             |          |                  |   |                 |        |       |              |             |

**Танилцсан**  
 АМГ-ын Геологийн албаны дарга /...../  
**Нэгтгэн боловсруулсан:**  
 ГА-ны мэргэжилтэн /...../

"Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 5 дугаар хавсралт

Захиалагч: Уул уурхайн яам

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн судалгааны ажлын  
20.. оны ... сарын гүйцэтгэл

Огноо

/төгрөгөөр/

| Д/д | Төслийн нэр | Эхлэх дуусах хугацаа | Гэрээний дүн | Өмнөх оны жилийн эцсээрх гүйцэтгэл | .... оны төлөвлөгөө | Тайлант хугацаанд гүйцэтгэсэн ажил | Хянасан |
|-----|-------------|----------------------|--------------|------------------------------------|---------------------|------------------------------------|---------|
| 1   |             |                      |              |                                    |                     |                                    |         |
|     |             |                      |              |                                    |                     |                                    |         |
|     | Дүн         |                      |              |                                    |                     |                                    |         |

Танилцсан:

УУЯ-ны ЭЗСХОХ-ийн дарга

/...../

Хянасан:

УУЯ-ны ЭЗСХОХ-ийн мэргэжилтэн

/...../

Танилцсан:

АМГ-ын дарга

/...../

АМГ-ын Геологийн албаны дарга

/...../

Хянасан:

АМГ-ын ГА-ны РСТ-ийн дарга

/...../

АМГ-ын ГА-ны РСТ-ийн мэргэжилтэн

/...../

"Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 6 дугаар хавсралт

**Геологийн мэдээллийн төвд тайлан, материал хүлээн авсан тухай мэдэгдэл**

1. Төслийн тайлангийн нэр, хувийн дугаар
2. Төслийн талбайн байршил :
3. Судалгааны төрөл, үе шат
4. Тайлан зохиогч
5. Геологийн даалгаврын хугацаа:  
/Хугацаа: он,сар/

Эхэлсэн: .....  
Дууссан: .....  
Өөрчилсөн: .....

6. Төслөөр гүйцэтгэсэн үндсэн ажил:

| Д/д | Гүйцэтгэсэн ажил | Хэмжих нэгж | Төсөл |     | Санхүүжилт |     |
|-----|------------------|-------------|-------|-----|------------|-----|
|     |                  |             | Тоо   | Дүн | Тоо        | Дүн |
|     |                  |             |       |     |            |     |
|     |                  |             |       |     |            |     |

7. Тайлан хамгаалсан хугацаа: Геологийн албанд ирүүлсэн:  
ЭБМЗ - өөр хэлэлцсэн :  
ГМТ- д хүлээлгэн өгсөн:

8. Тэмдэглэл: ...'  
(ГМТ-д хүлээлгэн өгсөн тайлангийн боть, хувь, хавсралт зураг, бичвэрийн дискийн тоо, хээрийн судалгааны анхдагч материал хүлээн авсан актын дугаар зэргийг тэмдэглэнэ)

Тайлан хүлээн авсан :

Тайлан хүлээлгэн өгсөн :

Геологийн  
мэдээллийн төв  
архивын эрхлэгч  
(тэмдэг)  
Мэргэжилтэн  
огноо

[Гүйцэтгэгч  
байгууллага] -  
ын захирал  
(тамга)  
Ерөнхий геологич  
огноо

..... ТАЛБАЙН 1:.....-НЫ МАСШТАБЫН ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕҮНХИЙ ЭРЛИЙН АЖЛЫН ... ОНЫ ТӨСӨВ, ТӨСВИЙН ТОДОТГОЛ

Гүйцэтгэгч: .....

Гэрээний үнд: .....

| №  | Ажлын нэр төрөл         | Хэмжих нэгж | Нэгжийн өртөг | Гэрээний дүн |            | 20.. оны төлөвлөгөө |            | 20.. оны гүйцэтгэл |            | Зөрүү        |            | 20.. оны төлөвлөгөө |            | 20.. оны гүйцэтгэл |            | Зөрүү        |            | 20.. оны төлөвлөгөө |            | 20.. оны төсвийн тодотгол |            | Зөрүү        |            | Гэрээний дүнгийн үлдэгдэл |            |              |
|----|-------------------------|-------------|---------------|--------------|------------|---------------------|------------|--------------------|------------|--------------|------------|---------------------|------------|--------------------|------------|--------------|------------|---------------------|------------|---------------------------|------------|--------------|------------|---------------------------|------------|--------------|
|    |                         |             |               | Ажлын хэмжээ | Нийт өртөг | Ажлын хэмжээ        | Нийт өртөг | Ажлын хэмжээ       | нийт өртөг | Ажлын хэмжээ | Нийт өртөг | Ажлын хэмжээ        | Нийт өртөг | Ажлын хэмжээ       | Нийт өртөг | Ажлын хэмжээ | Нийт өртөг | Ажлын хэмжээ        | Нийт өртөг | Ажлын хэмжээ              | Нийт өртөг | Ажлын хэмжээ | Нийт өртөг | Ажлын хэмжээ              | Нийт өртөг | Ажлын хэмжээ |
| 1  |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 2  |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 3  |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 4  |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 5  |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 6  |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 7  |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 8  |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 9  |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 10 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 11 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 12 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 13 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 14 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 15 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 16 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 17 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 18 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 19 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 20 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 21 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 22 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
| 23 |                         |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |
|    | <b>Нийт төсвийн дүн</b> |             |               |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                    |            |              |            |                     |            |                           |            |              |            |                           |            |              |

**Хянасан:**  
 АМГ-ын Геологийн албаны дарга /...../  
 АМГ-ын РСТ-ийн дарга /...../  
**Нэгтгэн боловсруулсан:**  
 АМГ-ын РСТ-ийн мэргэжилтэн /...../

**Гүйцэтгэгч:**  
 ....-ийн захирал /...../  
 ....-ийн ерөнхий нягтлан бодогч /...../



"Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 8 дугаар хавсралт

ЗӨВШӨӨРӨВ: АМГ-ЫН ДАРГА  
тамга /...../

ЗӨВШӨӨРӨВ: .....-ИЙН ЗАХИРАЛ  
тамга /...../

..... ТАЛБАЙН 1: .....-НЫ МАСШТАБТАЙ ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖЛЫН ..... ОНЫ ТӨСӨВ

Гүйцэтгэгч:

Гэрээний дүн:

/төгрөгөөр/

| № | Ажлын нэр | Хэмжих нэгж | Нэгжийн өртөг | Биет хэмжээ | Төсөвт өртөг |
|---|-----------|-------------|---------------|-------------|--------------|
| 1 |           |             |               |             |              |
|   |           |             |               |             |              |
|   | Дүн       |             |               |             |              |

**Танилцсан:**

УУЯ-ны ЭЗСХОХ-ийн дарга /...../

АМГ-ын Геологийн албаны дарга /...../

**Хянасан:**

АМГ-ын РСТ-ийн дарга /...../

АМГ-ын РСТ-ийн мэргэжилтэн /...../

**Гүйцэтгэгч:**

/тамга/

...-ийн ерөнхий нягтлан бодогч /...../

ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖИЛД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ЗАДАРГАА

Гэрээний дугаар .....

Гэрээний д үн: .....

| №  | Ажлын нэр төрөл                | Цалин | НДШимтгэл | Материалын зардал | Бичиг хэрэг | Сэлбэг хэрэгсэл | Томиллолт | Ашиглалтын зардал | Түрээсийн зардал | Түлш, шатахуун | Үндсэн хөрөнгийн элэгдэл | Тээврийн зардал | Хээрийн нэмэгдэл | Холбоо | Татвар | Гадны байгууллагаар гүйцэтгүүлсэн | Бусад зардал | Зардлын дүн |
|----|--------------------------------|-------|-----------|-------------------|-------------|-----------------|-----------|-------------------|------------------|----------------|--------------------------|-----------------|------------------|--------|--------|-----------------------------------|--------------|-------------|
| 1  | Төсөл, төсөв зохиолт           |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 2  | Агаар, сансрын зургийн тайлалт |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 3  | Геологийн зураглал             |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 4  | Эрлийн маршрут                 |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 5  | Талбайн сорьцлолт              |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 6  | Геохимийн судалгаа             |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 7  | Гидрогеологийн судалгаа        |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 8  | Геоморфологийн судалгаа        |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 9  | Геофизикийн ажил               |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 10 | Топогеодезийн ажил             |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 11 | Уулын ажил                     |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 12 | Өрөмдлөгийн ажил               |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 13 | Сорьцлолт                      |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 14 | Лабораторийн ажил              |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
| 15 | Суурин боловсруулалт           |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |
|    | <b>НИЙТ дүн</b>                |       |           |                   |             |                 |           |                   |                  |                |                          |                 |                  |        |        |                                   |              |             |

Гүйцэтгэгч: /тамга/

.....-ийн захирал

.....-ийн ерөнхий нягтлан бодогч

/...../

/...../